



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 77

Мандалговь

Г Автомашинд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт аймгийн иргэдийн Төлөөлөгчийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дундговь –Ус Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 11,517,267,42 /арван нэгэн сая таван зуун арван долоон мянга хоёр зуун жаран долоон төгрөг дөчин хоёр мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй 3 ширхэг хөрөнгийн худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн), Дундговь –Ус Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (О.Бархүү) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;


2.2 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцан, харуул хамгаалалттай байлгах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхэд хяналт тавих;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт

Дундговь-ус орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын
худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлдвэр лэсэн он	Ашиг лалта д орсон он	Санхүүгийн тайланда тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сер и	Дугаа р						
1	Дундговь-Ус ОНӨААТҮГ	Ус цэнгэгийн барилга, доорх газрын хамт			1998	1998	2,245,467,42	1,416,782,75	828,684,67	2,156,000
2	Дундговь-Ус ОНӨААТҮГ	KIA BONGO	ДУА	61-14	1986	2011	7,771,800	6,287,163,49	1,484,636,51	800,000
3	Дундговь-Ус ОНӨААТҮГ	KIA BONGO	ДУА	37-36	2006	2006	1,500,000	1,500,000	-	500,000
Нийт						11,517,267,42 /арван нэгэн сая таван зуун арван долоон мянга хоёр зуун жаран долоон төгрөг дөчин хоёр мөнгө/ төгрөг	9,203,946,24 /есөн сая хоёр зуун гурван мянга есөн зуун дөчин зургаан төгрөг хорин дөрвөн мөнгө/ төгрөг	2,313,321,18 /хоёр сая гурван зуун арван гурван мянга гурван зуун хорин нэгэн төгрөг арван найман мөнгө/ төгрөг	3,456,000 /гурван сая дөрвөн зуун тавин зургаан мянга/ төгрөг	